АРХАНГАЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

АРХАНГАЙ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАРТ ХООЛ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: Архангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хоол,хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: АРАШШГГ/202001001

Багцтай: 1-р багц Мах, махан бүтээгдэхүүн
2-р багц Төмс, хүнсний ногоо
3-р багц Хүнсний бүтээгдэхүүн

2021 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2021.01.19

Тендерийн дугаар: АРАШШГГ/202101001

Архангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хоол, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх /3 багцтай/** тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерт ирүүлэх барааны тоо хэмжээ болон техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй баримт бичгийг үнэ төлбөргүй татан авах боломжтой.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30000 /гучин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг ***2021 оны 02 дугаар сарын 01-ний 11 цаг 00 минут***аас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан ***2021 оны 02 дугаар сарын 01-ний 11 цаг 30 минут***[1]-т нээнэ.

Дотоод давуу эрх тооцох эсэх- Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Архангай аймгийн ЗДТГ-ын "А" корпус, 1 давхар, 111 тоот өрөө,
Архангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
Утас: 99065194, 80281313

Цахим хаяг: www.tender.gov.mn

[1] Тендерийгхүлээжавахэцсийнхугацаагдууссанаасхойш 1 цагийндоторбайна.

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	1.1.	Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт	2.1.	Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
	2.2.	Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл	3.1.	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ	4.1.	Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	5.1.	Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
	5.2.	Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1.	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш ***45*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ***ТШӨХ-д*** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТОӨЗ 1.1	**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ** Тендер шалгаруулалтын нэр: Архангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер Тендер шалгаруулалтын дугаар **:** АРАШШГГ/202101001 Дараах шаардлагуудыг тендерийн иж бүрдэл гэж үзнэ. 1. Сүүлийн 1 жил буюу 2020 оны санхүүгийн тайлан / эрх бүхий байгууллагаар баталгаажсан байх/ 2. Сүүлийн 1 жил буюу 2020 оны туршлагын мэдээлэл / ижил төстэй хийж гүйцэтгэсэн ажлын мэдээлэл ирүүлж буй багц тус бүрийн үнийн саналын 100%-тай тэнцэхүйц байх бөгөөд нотлох баримтын хамт ирүүлнэ. 3. Сүүлийн 1 жил буюу 2020 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ багц тус бүрт санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас багагүй байна. 4. Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас татсан хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. 5. Улсын бүртгэлийн гэрчилгээний үйл ажиллагааны чиглэлд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах заалттай байх. 6. Үнийн санал маягтаар ирүүлэх. 7. Бараа нийлүүлэх хуваарь ирүүлэх. 8. Тухайн бараа бүтээгдэхүүн нийлүүлэхэд хадгалалтын горимын шаардлага хангасан агуулах зоорь савтай байх / өөрийн болон түрээсийн эсэхийг нотлох баримт , фото зураг ирүүлэх/ 9. Тендерийн баримт бичгийн 3, 4-р бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрсөн тухай албан бичгээр мэдэгдэл гаргаж ирүүлнэ. 10. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа, тодорхойлолтыг тендерт оролцогч этгээд болон түүний удирдлагын нэрээр авч эх хувиар ирүүлнэ. 11. Татварын тодорхойлолтыг тендер нээсэн өдрөөр Татварын нэгдсэн цахим системээс татан авна. 12. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл ирүүлэх. 13. Нийлүүлэх бараа, бүтээгдэхүүн эрүүл ахуй, чанарын шаардлага хангаж байгааг нотлох баримт ирүүлэх Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана/

	Тендерт оролцогч нь Засгийн газрын 2015 оны 08-р сарын 17-ны өдрийн 336 тогтоолд тусгагдсан Дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан барааг ашиглах бол тухайн барааны нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртгийн талаар мэдээлэл ирүүлнэ үү. (Уг мэдээллийг тендерийн үнэлгээнд харгалзахгүй болно.) Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай. ТШӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно. Дээрхи нэмэлт материалуудаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй баталгаажилтгүй ба зөрчил бүхий нотлох баримтууд ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын *төсвийн урсгал зардлаар* ***24 050 000*** */хорин дөрвөн сая тавин мянга/ төгрөгөөр санхүүжигдэнэ.* • **1-р багц Мах, махан бүтээгдэхүүн-8 800 000** • **2-р багц Төмс, хүнсний ногоо-4 588 000** • **3-р багц Хүнсний бүтээгдэхүүн-11 662 000 төгрөгөөр 2021 онд санхүүжигдэнэ.**
ТОӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Тендер хүлээн авах этгээд: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтрэн орж тендерийн материалыг цахим хэлбэрээр ирүүлнэ. Огноо: ***2021 оны 02 дугаар сарын 01-ний*** **өдөр** Цаг**: 11 цаг 00 минут** Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авах боломжгүй.
ТОӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг:Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Огноо: ***2021 оны 02 дугаар сарын 01-ний*** **өдөр** Цаг**: 11 цаг 30 минут**
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: **Багцтай** Санхүүжилтийн эх үүсвэр: Улсын төсвийн урсгал зардал • **1-р багц Мах, махан бүтээгдэхүүн** • **2-р багц Төмс, хүнсний ногоо** • **3-р багц Хүнсний бүтээгдэхүүн**

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Мах махан бүтээгдэхүүн болон хүнсний бусад бүтээгдэхүүн

2. **Стандарт:** Тухайн бараа, бүтээгдэхүүний гарал үүсэл нь монгол улсын мөрдөж буй холбогдох стандартад нийцсэн байх.

3. **Баглаа, боодол :** Тус бүрд баталгаатай савалгаатай байх. Бүтээгдэхүүний баталгаат хугацаа тавьсан хэмжээг тодорхой заасан байна.

4. **Бараа хүргэх газар:** [Архангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт]

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Гэрээний хугацаанд нийлүүлэх хэмжээгээр

Бараа нийлүүлэлтийн тоо хэмжээг цахим сайтын ТЭЗҮ-д байршуулсан болно.

Тайлбар:

1. Мах, дайвар бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мал, амьтны мах, малын гэдэс дотор, толгой шийр орно. Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй.

2. Төмс, хүнсний ногоо гэдэгт дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй.

3. Будаа гэдэгт бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шар буурцгийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна.

Мах, махан бүтээгдэхүүнд тавигдах техникийн ерөнхий шаардлага

№	Техникийн үзүүлэлт тавигдах шаардлага
	- Гарал, үүслийн гэрчилгээтэй байна - Өнгө үзэмж сайтай байх - Эрүүл ахуйн шаардлага хангасан байх - Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх - Тээвэрлэлт, Хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. - Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх. - Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх

Хүнсний бэлэн бүтээгдэхүүнд тавигдах техникийн ерөнхий шаардлага

№	Техникийн үзүүлэлт тавигдах шаардлага
	- Гарал, үүслийн гэрчилгээтэй байна - Өнгө үзэмж сайтай байх - Эрүүл ахуйн шаардлага хангасан байх - Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх - Тээвэрлэлт, Хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. - Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх. - Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх

Барааны нэр: БУУДАЙН ГУРИЛ: Буудайн гурилыг “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим/ олон улсын зөвлөмж/” MNS CAC /RCP 1:2003 стандарт шаардалга хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн байна.
Хүнсний нэмэлтийн хэмжээ нь MNS CAC 192:2007 стандартыг хангсан байна.
Савласан бүтээгдэхүүний стандарт нь MNS ISO 7301:2000 стандартыг хангасан байна.

Мэдрэхүйн үзүүлэлт нь доорх шаардлагыг хангасан байна.

Үзүүлэлт	БГ045, БГТ045, БГ-050, БГ-055, БГТ-055	БГТ-075, БГ-085	Нийлүүлэгчийн санал болгосон барааны үзүүлэлт
Өнгө	Цагаан буюу цагаан шаргал туяатай цагаан	Цагаан буюу шаравтар туяатай цагаан	
Үнэр	Буудайн гурилын хэвийн үнэртэй, исгэлэн буюу хөгцний зэрэг гадны үнэргүй байна		
Амт	Буудайн гурилын хэвийн амттай, исгэлэн гашуун, чихэрлэг амтгүй байна		
Эрдэс хольц	Зажлахад элсэрхэг буюу хатуу зүйл		

Барааны нэр: **ЦАГААН БУДАА**
Цагаан будаа нь MNS ISO 7301;2000 стандартыг хангасан эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээнд хамруулсан байна.
Мэдрэхүйн үзүүлэлт нь: доорх шаардлагыг хангасан байна.

Үзүүлэлт	Шаардлага MNS ISO 7301;2000	Нийлүүлэгчийн санал болгосон барааны үзүүлэлт
Өнгө	Цайвар шаргал цагаан өнгөтэй	
Амт	Хээггүй, механик хольцгүй, гаж буруу гадны нөлөөний амтгүй байна	
Чанар	Эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан, шороогүй	
Битүүмжлэл	Зориулалтын сав баглаа боодолтой, гадны гэмтэл, нөлөөнөөс хамгаалсан байх	
Хадгалах хугацаа	Хугацаа хэтрээгүй байх	

Барааны нэр: **ХӨӨЛГӨГЧ**
Хөөлгөгч нь MNS (CAC)4293;1995стандарттай дүйцэхүйц эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамруулсан байна.
Хөөлөгчийн мэдрэхүйн үзүүлэлт нь.

Үзүүлэлт	Шаардалага	Нийлүүлэгчийн санал болгосон барааны үзүүлэлт

Өнгө	Шаргал туяатай, сааралдуу өнгөтэй, бараан толбогүй	
Үнэр	Хөгц, ба гадны ямар нэгэн үнэргүй	
Амт	Гадны ямар нэгэн амтгүй	
Чанар	Задлахад нунтаг байдалтай	
Битүүмжлэл	Хэвийн	
Хөөлгөх чадвар /минут/	70-аас дээшгүй	
Хүчиллэг /мг/	102,0	
Чийглэг	Хуурай наалдаагүй	
Хадгалах хугацаа	Хэтрээгүй байна.	

Барааны нэр. **УРГАМЛЫН ТОС**

Ургамалын тос нь MNS (CAC)125;1998 стандартыг хангасан эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгаанд хамруулсан байх.

Ургамалын тосны мэдрэхүйн үзүүлэлт нь доорх шаардлагыг хангасан байна. Үзүүлэлт	шаардлага	Нийлүүлэгчийн санал болгосон барааны үзүүлэлт
Өнгө	Цайвар шар өнгөтэй, тунгалаг тундас үүсээгүй байх	
Үнэр	Өөрийн өвөрмөц үнэртэй, гаж үнэргүй байх	
амт	Нэр төрөлдөө тохирсон амттай байх	
Хадгалах хугацаа	Хугацаа хэтрээгүй байх	

Барааны нэр: **ЭЛСЭН ЧИХЭР**

Элсэн чихэр нь MNS(CAC) 4;95 стандарттай дүйцэхүйц стандарт эрүүл ахуйн шаардалга хангасан байх

Элсэн чихрийн мэдрэхүйн үзүүлэлт нь доорх шаардлагыг хангасан байна. Үзүүлэлт	Шаардлага	Нийлүүлэгчийн санал болгосон барааны үзүүлэлт
Өнгө	Жигд нарийн ширхэгтэй, цагаан өнгөтэй, уусмал нь тунгалаг өнгөтэй байна	
Үнэр	Өөрийн төрлийн үнэртэй	
Амт	Өөрийн төрлийн чихэрлэг амттай	
Чанар	Уусалт сайн	
Хэлбэр дүрс	Нэр төрөлдөө тохирсон хэлбэртэй байх	
Эрдэс хольц	Гадны хольцгүй	

Барааны нэр: **ТӨМС**

№	Төмсний чанарын шаардлага	Эрт ургацын	Орой ургацын	
			1-р зэрэг	2-р зэрэг
1	*Гадаад байдал*	*Өвчин, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, бүтэн, хуурай, сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан байна.*		
2	*Хальсны бэхжилт*	*Шалбарсан байж болох боловч махлаг эд нь хүрэнтэж зөөлрөөгүй байна.*		*Хальс нь бэхэжсэн байна. Хальс нь шалбарсан төмс 10,0%-аас их байж болохгүй.*
3	*Төмсний голч хэмжээ, мм-ээс багагүй байна*	35		
4	*Жижиг төмс /40г-аас доош/*	*Байж болохгүй*		
5	*Хэлбэр дүрсээ алдсан төмс %, ихгүй*	*Байж болохгүй*		

5.2 Төмс нь гадны ямар нэг үнэртэй, химийн хорт бодисоор бохирлогдсон байж болохгүй
5.3 Төмсний гадаргуу цэвэр, шороогүй байх èстой
5.4 Төмсний аюулгүй байдлын үзүүлэлт нь 2-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байвал зохино

Барааны нэр: **БӨӨРӨНХИЙ БАЙЦАА**

№	Үзүүлэлт	Техникийн тодорхойлолт	
		Нэгдүгээр	Хоёрдугаар
1	Гадаад байдал	Шинэ бүтэн, цэвэр гадны үнэр, амтгүй байна. Толгой нь нягтарсан байна.	Шинэ бүтэн, цэвэр гадны үнэр амтгүй байна. Толгой нь гүйцэд нягтраагүй сулавтар байж болно
2	Өнгө	Цайвар ногоон	
3	Ишний урт, см дээшгүй	3	3
4	Гэмтлийн хэмжээ	Гадна талын 1 навч шалбарсан байж болно бусад бүх гэмтлийг хүлээн зөвшөөрөхгүй	Дунд

Барааны нэр: Бусад хүнсний ногоо

№	Техникийн үзүүлэлт тавигдах шаардлага
	- Гарал, үүслийн гэрчилгээтэй байна - Өнгө үзэмж сайтай байх - Эрүүл ахуйн шаардлага хангасан байх - Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх - Тээвэрлэлт, Хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. - Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх. - Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Д.Тулга танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]* дор дурдсан барааг ***[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ***[тоо]*** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн барааND олгодог баталгаат засварын хугацаа ***[1]*** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ***[30]*** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. **ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

1. Шалгах болон турших (ГЕН – 1)	1.1.	[Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)	2.1.	Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)	5.1.	Баталгаат засварын тусгай шаардлага-**Найдвартай ажиллагааны баталгаа гаргаж өгнө**
4. Төлбөр (ГЕН – 7)	7.1.	Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Гэрээний үнийн дүнгийн ***100*** [2]хувийг**тоног төхөөрөмж** хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

[2]Ихэнхтохиолдолд 100 хувьбайна. Шаардлагатайболтөлбөрийнхуваарийгөөрчилнө.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)[3]	9.1.	Алданги оногдуулах хувь: ***0,03%***
		Алдангийн нийт дүн: ***Гэрээний үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй***

[3] Ихэнхтохиолдолд, нэгдолоохоногтоногдуулахалдангигэрээнийүнийн 0.5 хувиас, алдангийннийтдүнгэрээнийүнийндүнгийн 10 хувиастустусхэтрэхгүй.

Долоо. **ГЭРЭЭНИЙ МАЯГТ**[4]

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	**НИЙЛҮҮЛЭГЧ**
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

***[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]* гэрээ.**

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэр]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ***[нийлүүлэгчийн нэр]*** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь ***[гэрээний нэр, дугаар]***-г (цаашид “бараа” гэх) ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]*** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь _____ программыг _____ оны __ дугаар сарын ___-наас _____ оны __ дугаар сарын ___-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

[4] Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг[5];
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

9.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:	**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
[Албан тушаал, нэр] *[Гарын үсэг]*_____	*[Албан тушаал, нэр]* *[Гарын үсэг]*_____
ТАМГА	ТАМГА
[Захиалагчийн хаяг] *[Утас/факсын дугаар]* *[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*	*[Захиалагчийн хаяг]* *[Утас/факсын дугаар]* *[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

[5] Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.